



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/638

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.11 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1/2675 дугаартай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд" Аймгийн Засаг даргын 2024 оны А/370, А/371 дугаартай захирамжийг хүчингүй болгох талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Шаравгаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичиг:	Б.Энхтайван	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Уламбаяр	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ